



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: (976-51) 26 23 50, Цахим шуудан: info@pcsp.gov.mn,
Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2026.03.20 № А-1/507
танай _____-ны № _____-т

**ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН
ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ,
ЗАХИРАЛ НАРТ**

Сургалтад хамруулах тухай

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (PCSP), Азийн Хөгжлийн банк (ADB), Компанийн засаглалын хөгжлийн төв (CGDC) хамтран төрийн болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газруудын засаглалд олон улсын сайн туршлага, зарчмыг нэвтрүүлэх, Төлөөлөн удирдах зөвлөл болон удирдлагын багийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй сайжруулах зорилгоор “Төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудын дотоодын “Засаглалын сургагч багш бэлтгэх” дипломын сургалтыг 2026 оны 2 болон 4 дүгээр улиралд зохион байгуулах гэж байна.


Сургалтаар төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын засаглалын хөгжлийн чиг хандлага, Төлөөлөн удирдах зөвлөлийн төрөлжилт, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнийг оновчтой зохион байгуулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн үнэлгээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн үр бүтээлтэй үйл ажиллагаа, компани, үйлдвэрийн газрын санхүүгийн үзүүлэлтүүдийг ойлгож, удирдах, хөрөнгө оруулалтын шинжилгээ, бизнес төлөвлөгөө ба бизнесийн үнэлгээ зэрэг цогц ойлголтуудыг заана. Мөн сурган, заах арга зүй, манлайлал ба сэтгэлзүйн чадамжийн сургалтууд орно.

Сургалтад Компанийн засаглалын чиглэлээр ажилладаг, анхан шатны сургалтад хамрагдсан, цаашид өөрийн ажиллаж буй компанидаа засаглалын сургалт явуулах, Төлөөлөн удирдах зөвлөлд үнэлгээ хийх, зөвлөгөө өгөх хүсэл сонирхол бүхий албан хаагчид оролцох боломжтой.

Иймд дээрх сургалтад албан хаагчдаа хамруулан ажиллахыг хүсье.

Сургалтын хөтөлбөрийг хавсаргав.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132001410

A-4/2026